

БАТЛАВ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА

ОЙН ҮРИЙН ТАЛБАЙ ТУСГААРЛАХ, ОЙН ҮРИЙН ТАЛБАЙН
АРЧИЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР
/ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 31- ний өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө"-д тусгагдсан ойн үрийн талбай тусгаарлах, ойн үрийн талбайн арчилгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хамрах хүрээ	Ойн үрийн талбай тусгаарлах, ойн үрийн талбайд арчилгаа хийх ажлыг хийж гүйцэтгэнэ. Талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав.
3	Төсөвт өртөг	118,500,000.00 /нэг зуун арван найман сая таван зуун мянган/ төгрөг
4	Талбайн хэмжээ	100 га /Ойн үрийн талбай тусгаарлах 50га, үрийн талбайн арчилгаа хийх 50га/
5	Техникийн шаардлага	Ойн үрийн байнгын талбай байгуулахад тавигдах ерөнхий шаардлага MNS 6531:2019 стандарт шаардлагыг хангасан байна
6	Хугацаа	Шалгарч гэрээ байгуулснаас хойш 2025 оны 11 дүгээр сарын 29 хүртэл
7	Хийх ажил	Дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> Бэлтгэл ажил Ойн үрийн байнгын талбай тусгаарлах, үрийн талбайн арчилгаа хийх Ойн үрийн талбайг орон нутгийн ойн ангид актаар хүлээлгэн өгөх Зөрчил гологдол арилгах Тайлан боловсруулах Тайлан, акт хүлээлгэн өгөх /Ойн газарт /
9	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	Ойн үрийн талбай тусгаарлах, ойн үрийн талбайн арчилгаа хийх ажилбарууд: <ul style="list-style-type: none"> Ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах; Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах

9	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p>Ойн үрийн талбай тусгаарлах, ойн үрийн талбайн арчилгаа хийх ажилбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах; • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах • Ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох; • Ойн үрийн талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцөн сонгох/; <p>Ойн үрийн байнгын талбай байгуулахад тавигдах ерөнхий шаардлага: MNS 6531:2019 стандартын дагуу хаягжуулалт, шонг хийх;</p>
10		<p>Ойн үрийн талбай тусгаарлахад хийгдэх ажлууд</p> <ul style="list-style-type: none"> • Ойн үрийн байнгын талбай байгуулахад тавигдах ерөнхий шаардлага: MNS 6531:2019 стандартыг мөрдөн ажиллах; • Ойн үрийн байнгын талбайг сонгох • Ойн үрийн байнгын талбайд тооллого хэмжилт хийх; • Ойн үрийн байнгын талбай арчилгаа хийх; • Ойн үрийн байнгын талбай түймрээс хамгаалах зурвас хийх; • Ойн үрийн байнгын талбай бүртгэх, бичиг баримт олгох. • Ойн үрийн байнгын талбай тусгаарлах, тэмдэгжүүлэх, хаягжуулах; • Ойн үрийн байнгын талбайн паспорт хийх /MNS6531:2019 стандартын А хавсралт/ • Ойн үрийн байнгын талбайд арчилгаа хийсэн тэмдэглэл хөтлөх /MNS6531:2019 стандартын 5/ • Ойн үрын байнгын талбайн нэгдсэн хүснэгт хийх /MNS6531:2019 стандартын В хавсралт/
11	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p>Ойн үрийн байнгын талбай байгуулах, тусгаарлах ажил</p> <ul style="list-style-type: none"> • Уулын ойн зүүн урд, баруун хойд, хойд зүгт чиглэсэн 10 градусуаас илүүгүй налуутай байна. • Ойн бонитет I болон II ангид хамаарагдах ой, хэрэв тухайн бүс нутагт байхгүй нөхцөлд III анги, Төв Азийн цөл-хээрийн ой ургамалжилтын мужийн шилмүүст ойд

бонитетийн IV ангид хамаарах ойг сонгож болно.

- Ойн үрийн байнгын талбайн эргэн тойронд түймрээс хамгаалах зорилгоор 10м-ийн өргөнтэй шороон зурвас гаргана.
- Үрийн талбайн өтгөрөл нарс, шинэс, хусан ойд 0,3-0,6 өтгөрөлтэй байна.
- Үрийн талбайд эх модны тоо багадаа 40 хувиас багагүй байна. Эх модны зай хоорондоо 200м -ээс ихгүй байна.
- Өсөлт ургалт муутай ойгоос дунджаар 300м-ийн хол зайтай байхаар үрийн байнгын талбайг байгуулна.
- Ямар ч үед тээврийн хэрэгсэл саадгүй очих боломжтой байх, боломжийг хангасан байх
- Ойн үрийн байнгын талбайг 5-р сарын сүүлээс 10-р сарын дунд үе хүртэл хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- Сонгосон талбайд арчилгаа хийх замаар жигд цэцэглэх өсөлт хөгжилт хэвийн явагдах, тоос их хүртэх тохиромжтой нөхцөлийг хангана. Талбайд байгаа унанги хатсан модыг цэвэрлэнэ.
- Арчилгааны ажлыг хийхийн өмнө эрүүл, өсөлт сайтай, ишний хэлбэр зөв, титэм эргэн тойрон жигд конус хэлбэртэй моддыг сонгон газрын гадаргаас 1.3м өндөрт цагаан өнгийн тосон будгаар тэмдэг тавина.
- Ойн үрийн талбайд арчилгааны ажил хийхээс гадна хортонд нэрвэгдсэн, өсөлт хөгжилт муутай селекцийн үнэлгээ доогуур чанарын моддыг огтолно.
- Титмийн хоорондын зай нарс, гацуур, жодоо ойд 0,5-0,7м, шинэсэн ойд 0,4-0,5м байхаар гүйцэтгэнэ.

Хүснэгт 1

Ойн үрийн байнгын талбайд 1 га-д үлдэх модны тоо төрөл тус бүрээр

Модны төрөл	Нас /жилээр/	Үлдэх үр түүх модны тоо
Нарсан ойд	30-40	200-250
Шинэс ойд	30-40	150-200

12

Ойн үрийн байнгын талбайд хийх арчилгааны ажил

- Ой, модонд селекцийн үнэлгээ, тооллого хийх;
- Үрийн модыг сонгох, тэмдэглэх сийрэгжүүлэх огтлолт хийх
- Арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх
- Ойн үрийн байнгын талбайгаас сайн чанарын үр авахын тулд титмийг хэлбэржүүлэх, титмийн доод мөчрийг танах, мод бүрийн эргэн тойрны хөрсийг сийрүүлэх арчилгааг хийнэ.
- Мод хоорондын зайд хөрсийг боловсруулж хөрсний үржил шимийг сайжруулах
- Түймрээс хамгаалах зурвасыг сэргээх
- Үр түүхэд саад учруулах бут сөөгийг огтолж талбайг цэвэрлэх
- Өвчилсөн, хортонд идэгдсэн модыг тухай бүрд нь огтлох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.

		<ul style="list-style-type: none"> • Тусгаарласан талбайн моднуудын тэмдэглэгээг сэргээх • Талбайн 4 шон, самбарыг сэргээх
13		<p>Ойн үрийн байнгын талбайд тооллого явуулж, хяналт тавих</p> <ul style="list-style-type: none"> • Ойн үрийн байнгын талбай байгуулсан тохиолдолд БОАЖГ, ойн алба болон ойн ангийн мэргэжилтний хяналтын дор гүйцэтгэнэ. Ойн ангийн мэргэжилтнүүд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулна. • Ойн үрийн байнгын талбайд паспортын А хавсралтын дагуу хөтөлнө • Ойн үрийн байнгын талбайн дугаарыг ойн анги олгоно • Ойн үрийн байнгын талбайд сийрүүлэх огтлолт хийхэд ойн анги газар дээр нь шалгаж ажлын чанар, бичиг баримтын хөтлөлтөд үнэлгээ өгч ажиллана • Үр түүх мод бүрийг дугаарлана. • Ойн үрийн байнгын талбай байгалийн хүчин зүйлээс болж шатсан, хортонд бүрэн нэрвэгдсэн, үерт автсан, хүчтэй салхи, хөрсний гулсалтад нэрвэгдэн ашиглах боломжгүй болсон тохиолдолд паспортад тэмдэглэл хийж, бүртгэлээс хасах ажлыг Ойн анги гүйцэтгэнэ.
14		<p>Ойн үрийн байнгын талбай тусгаарлах, тэмдэгжүүлэх, хаягжуулах;</p> <ul style="list-style-type: none"> • Үр түүх байнгын талбайн эргэн тойронд түймрээс хамгаалах зорилгоор 10м өргөнтэй шороон зурвас гаргана. • Талбайн гадна талд хоёр хөлтэй 60 х 100 см-ийн харьцаатай самбар дээр хаяг байрлуулна. Самбар дээр талбай тусгаарласан мэдээллүүдийг байршуулна. • Хилийн шонг зургийн дагуу хийнэ. Шонгийн нүүрэнд газрын нэр, хэсэглэл, ялгарал, үрийн байнгын талбайн дугаар, талбай тусгаарласан он зэргийг тэмдэглэнэ. <div style="text-align: center;"> </div> <p>MNS6531:2019 стандарт. Ойн талбайн хаягжуулалт</p> <p style="text-align: right;">үрийн</p>

15	<p>Зөрчил, гологдол арилгах. Ойн үрийн байнгын талбай байгуулахад тавигдах ерөнхий шаардлага: MNS 6531:2019 стандарт шаардлагыг хангасан байна. Стандартын шаардлага хангаагүй тохиолдолд зөрчил гологдлыг арилгаж ойн ангил уг талбайгаа ойн ангид актаар хүлээлгэн өгнө.</p>
16	<p>Тайлан боловсруулах.</p> <p>а/ Ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд</p> <p>б/ “Ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>в/ 1:50000-ны масштабтай талбайн зураг</p> <ul style="list-style-type: none"> • Ойн үрийн байнгын талбай тусгаарласан; • Ойн үрийн талбайд арчилгаа хийсэн; <p>Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>г/ Ойн үрийн талбай тусгаарласан, үрийн талбайд арчилгаа хийсэн ажлуудыг орон нутагт хүлээлгэж өгсөн тухай</p> <ul style="list-style-type: none"> • Засаг даргын ажлын хэсэг томилсон захирамж • Ойн үрийн байнгын талбай үрийн талбайн арчилгааны ажил хүлээж авсан ажлын хэсгийн хурлын тэмдэглэл • Ойн үрийн байнгын талбай, үрийн талбайн арчилгааны ажил хүлээж авсан акт <p>д/ Ажлын үе шатны хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэл, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Талбайн тооллого, селекцийн үнэлгээний хүснэгт, материал болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, талбайн ерөнхий байдлын зураг, талбайд байгаа тэмдэгжүүлсэн мод, шон, хаягжуулалтын зургийг тайланд хавсаргана.</p> <p>е/ - Ойн үрийн байнгын талбай тусгаарлах -Ойн үрийн талбайн арчилгааны ажил тус бүр дээр хийсэн ажлын тайлан, зураг, ирүүлэхийг анхаарна уу. Ойжуулалтын ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ</p>
17	<p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх Ойжуулалтын ажлын тайланг Ойн газарт гурван хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p>

Ажил гүйцэтгэх байршил /багцын мэдээлэл/

№	Багцын дугаар	Багцын нэр	Байршил	Талбай /га/	1 га зардал төгрөгөөр	Төсөвт өртөг, төг
1	Багц 1	Дархан-Уул аймагт үрийн талбай тусгаарлах, үрийн талбайд арчилгаа хийх	Дархан аймгийн Хонгор сум	10	1,400,000.00	18,850,000.00
			Хонгор сумын Моностойд ойн үрийн талбайд арчилгаа хийх	5	970,000.00	
2	Багц 2	Сэлэнгэ аймагт үрийн талбай тусгаарлах, үрийн талбайд арчилгаа хийх	Алтанбулаг сум Гээнзэлд	15	1,400,000.00	41,580,000.00
			Алтанбулаг сум Баянбулгийн эх	5	1,400,000.00	
			Алтанбулаг сум Хондод	14	970,000.00	
3	Багц 3	Өвөрхангай, Хэнтий аймагт ойн үрийн талбай тусгаарлах	Бат-Өлзий сум Зүүн сөдтид ойн үрийн талбайд арчилгаа хийх	10	1,400,000.00	28,000,000.00
			Өмнөдэлгэр сум Баянзүрх багт ойн үрийн талбайд арчилгаа хийх	10	1,400,000.00	
4	Багц-4	Булган аймагт үрийн талбайн арчилгааны ажил хийх	Булган аймгийн Тэшиг сумын Халзан даваанд ойн үрийн талбайд арчилгаа хийх	5	970,000.00	9,700,000.00
			Булган аймгийн Баян-Агт суманд Мэргэн хөтөл ойн үрийн талбайд арчилгаа хийх	5	970,000.00	
5	Багц-5	Дорнод аймагт үрийн талбайн арчилгааны ажил хийх	Дорнод аймаг Баян-Уул сум Нарсан булаг, Баруун-арбулагт ойн үрийн талбайд арчилгаа хийх	8	970,000.00	7,760,000.00
6	Багц-6	Төв аймагт ойн үрийн талбайн арчилгааны ажил хийх	Төв аймгийн Мөнгөн морьт сум Зүүн наран ойн үрийн талбайд арчилгаа хийх	3	970,000.00	12,610,000.00

		Төв аймгийн Мөнгөн морьт сум Барууннаран ойн үрийн талбайд арчилгаа хийх	5	970,000.00	
		Төв аймгийн Мөнгөн морьт сум Зүүн оройн мод ойн үрийн талбайд арчилгаа хийх	5	970,000.00	
Дүн				100	118,500,000.00

Хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Боловсруулсан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойн үрийн нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн


Б.Ганзориг


Б.Өсөхбаяр


Н.Энхтуяа